



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026.07.06 № 0118250  
танай 2026.06.18 -ны № 36 -т

### Хариу хүргүүлэх тухай

Таны Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар асуулга ирүүлсэнтэй танилцлаа.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-д “орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг” гэж заасан байдаг.

Таны асуулгын дагуу дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд 2013 хуваарилсан шилжүүлгийн мэдээллийг албан бичгийн хавсралтаар;

2. Асуулгын 2 болон 6-д орон нутгийн төсөвт хамаарах буюу шат шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төсөл, арга хэмжээ түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл хүссэн байна.

Чиг үүргийн хүрээнд шат шатны засаг дарга нь орон нутгийн хөгжлийн сангийн буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилладаг.

Иймд 2 болон 6 дугаар асуулга дахь төсөл, арга хэмжээний тоо, ашиглалтад ороогүй, дутуу хэрэгжсэн, чанарын шаардлага хангаагүй, аудитын зөрчилтэй гэж тогтоогдсон төслийн тоо, аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны болон ашиг сонирхлын зөрчил, хууль бус зарцуулалт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авах;

3. Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтад “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавина” гэж заасны дагуу Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын газар нь тухайн жилийн “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг.

Хяналт шалгалтын хүрээнд аймгуудын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад Төсвийн тухай хууль, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу

хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч, холбогдох захиргааны арга хэмжээг авч, түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

**Аймгийн төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүд**

*1.Баянхонгор аймгийн 2014, 2015 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:*

- Баянхонгор аймгийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор айл өрхийг утаа бага гаргадаг зуухаар хангах ажлыг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн байна. Уг зуухыг нийлүүлэхээр "Их тэнгэрийн хүч" ХХК тендерт шалгарч 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн БХ-2014/03 тоот гэрээ байгуулсан бөгөөд гэрээгээр нэг бүр нь 270.0 мянган төгрөгийн үнэтэй 2,575 ширхэг утаагүй зуухыг нийлүүлэхээр болсон байна. Нийт 695.3 сая төгрөгийг гүйцэтгэгч компанид олгохоос 128.8 сая төгрөгийн иргэдээс төлүүлэн, 566.5 сая төгрөгийг Аймгийн ЗДТГ-аас санхүүжүүлэхээр гэрээнд тусгажээ. Иргэдээс төлөгдөх 128.8 сая төгрөг ЗДТГ-т төвлөрөхөөс 2015 оны 09 дүгээр сарын байдлаар 117.7 сая төгрөг орж ирсэн ба үлдэгдэл 10.8 сая төгрөгийг Аймгийн ЗДТГ-т авлагаар бүртгээгүй байна.
- Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу автозам болон дахин төлөвлөлтөд орсон газрыг чөлөөлж, нөхөн олговор олгох ажлын хүрээнд Баянхонгор сумын Номгон 1-р багийн нутагт байрлах ашиглах боломжгүй болсон 12 айлын 6-р байрыг буулгаж өөрийн материалаар олон улсын стандартад нийцсэн 25 айлын орон сууцны барилга бариулахаар "Скейл" ХХК-тай 2014 оны 06 дугаар сарын 24-ны өдөр гэрээ байгуулсан байна. Гэрээгээр гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр 1,060.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх бөгөөд захиалагч хуучин байранд амьдарч байсан өрхүүдэд олгох нөхөн төлбөр өрх бүрд 20.0 сая төгрөг нийт 240.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг ЗДТГ-аас олгож, гүйцэтгэгч орон сууцыг зарж дууссаны дараа захиалагч тал буюу ЗДТГ-т буцааж олгохоор гэрээ байгуулжээ. Гэрээний дагуу тус компаниас авах авлагыг авлагад тусгаагүй байна.
- Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 7/1 тоот төсөвт тодотгол хийх тухай тогтоолоор Баянхонгор сумын 2 дугаар багийн АЦДШ-ын өргөтгөлийн ажилд 32.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсний дагуу "Эрчим хүч ЦТ" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэлээр 32.0 сая төгрөг олгожээ. Ингэхдээ 569.1 мянган төгрөгийг магадалшгүй ажлыг гүйцэтгэлийн актгүйгээр олгосон байна.

Аймгийн төвийн 5.6 км хатуу хучилттай замын ажлыг хийж дуусгах ажил он дамжиж хийгдсэн бөгөөд гүйцэтгэгчээр "Саруул жим" ХХК шалгарч 2013 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн БХ-2013/03 тоот гэрээ байгуулсан ба гэрээний нийт дүн 3,300.0 сая төгрөг байна. 2014 онд Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 6/2 тоот тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2,050.0 сая төгрөгийн санхүүжилд олгохоор болсон байна. Тус ажилд гүйцэтгэлээр 2013, 2014 онуудад нийт 3,313.8 сая төгрөг олгогдож гэрээний үнийн дүнгээс 13.8 сая төгрөг илүү олгосон байна. Мөн 54.1 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг гүйцэтгэлийн актгүйгээр шилжүүлсэн бөгөөд 2015 оны 09 дүгээр сарын байдлаар гүйцэтгэлийн акт огт ирүүлээгүй байна.

- 2015 онд Аймгийн Аудитын газар нь улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит хийсэн байна. Тус аудитаар Баянхонгор сумын 3-р багийн цэцэрлэгийн барилгын санхүүжилтийг 695.1 сая төгрөгөөр аймгийн Төрийн санд эрх нээсэн боловч экспертээр уг барилгын төсөвт өртөг 686.0 сая төгрөгөөр хянагдсан ба зөрүү 9.1 сая төгрөг, мөн бусад ашиглалтад авсан төсөл, арга хэмжээний хяналтын зардлын үлдэгдэл 27.4 сая төгрөг, нийт 36.5 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлээгүй байсныг илрүүлжээ. Тус үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлэх байсан хэдий ч Аймгийн аудитын газрын хүү торгуулийн орлогын дансанд төвлөрүүлэхээр акт тавьсан байна.
- Баянговь сумын соёлын төвийн барилгын ажлаас 2014 онд зарцуулагдаагүй үлдэгдэл 24.3 сая төгрөг үлдсэн байсныг төсөвт төвлөрүүлээгүй байна.

### **2.Баян-Өлгий аймгийн 2014, 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилахдаа “Төсвийн тухай” хуулийн 59.2-т “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэсэн заалтыг зөрчин 46.5 хувь буюу 2,287.8 сая төгрөгийг сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилсан байна.

### **3.Сэлэнгэ аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- 2016 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 93 ажил, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд Орон нутгийн өмчийн газраас гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтын гэрээний тусгай нөхцөлийн 45-д заасны дагуу барьцаа хөрөнгийн хэмжээг тусгаж өгөөгүй, хуулийн дагуу барилга байгууламж барих, засвар тохижилт хийх зэрэг ажлын баталгаат хугацаанд 5 хувийн барьцаа хөрөнгийг барьцааны дансанд төвлөрүүлж, захиалагчийн хяналтын зардал болон магадалшгүй ажлын зардлын тооцооллыг хийж хянаж санхүүжүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулаагүй байна.
- Захиалагчийн ажлын техник хяналтын зардал нэрээр шилжүүлсэн хөрөнгийг үйл ажиллагааныхаа зориулалтын дагуу зарцуулдаггүй, техникийн хяналт хийгдсэн эсэхийг хянаж санхүүжилтийг олгодоггүйгээс бодит ажлын гүйцэтгэл, үр дүн хангалтгүй байна.
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 1,913.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 арга хэмжээнд сонгон шалгаруулалт зарлаж гүйцэтгэгч байгууллагатай 1,297.0 сая төгрөгийн гэрээ байгуулж дээрх ажлуудыг холбогдох байгууллагын мэдэлд шилжүүлснээс нэр бүхий 6 байгууллага 333.5 сая төгрөгийн ажлыг хүлээж авснаар санхүүгийн тайланд тусгаж 26 байгууллагын 963.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл үр дүн тооцогдоогүй байна.
- 32 байгууллагад 1,699.9 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 620.0 сая төгрөгийн, нийт 2,319.9 сая төгрөгийн 42 ажил хийгдэхээр батлагдсанаас 1,557.0 сая төгрөгийн гэрээ хийж 283.5 сая төгрөгийн өртөг бүхий 5 ажлыг хүлээн авч 1,273.5 сая төгрөгийн өртөг бүхий дараах ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй.

- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд талуудын хүлээх эрх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгаагүй, гэрээг хугацаанд нь дүгнэхгүй байгаа нь төсөл, арга хэмжээг цаг хугацаанд хэрэгжүүлэхгүй байх үндсэн нөхцөл болж байна. Захиалагчийн техникийн хяналтын гэрээг хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэгч компанитай байгуулж санхүүжилтийг гүйцэтгэгч компаниар дамжуулан олгож байгаа нь хяналт бүрэн хэрэгжихгүй байх, улмаар төсөл арга хэмжээ чанаргүй гүйцэтгэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

#### **4. Дархан-Уул аймгийн 2016, 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар аймгийн худалдан авах ажиллагааг хариуцан ажиллаж байхад Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг Аймгийн Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс сонгон шалгаруулалтыг хийж, гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
- 2016 онд нийт 33 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг 2016 оны 8,9 дүгээр сараас хойш шилжүүлсэн нь хугацаа алдаж гэрээт ажил цаг хугацаандаа дуусахгүй он дамжсан байна.

#### **5. Дорнод аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Аймгаас сумдад олгохоор төлөвлөсөн орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал"-ын дагуу хуваарилсан эсэхийг үзэхэд сумдад 41.3 хувь буюу 1,630.5 сая төгрөгийг, аймагт 58.7 хувь буюу 2,313.2 сая төгрөгийг хуваарилж олгосон нь хуульд заасан 30-аас доошгүй хувийг хуваарилах гэсэнд нийцэж байгаа хэдий ч хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавх зэргийг харгалзан хийх хуваарилалтыг 84.8 сая төгрөгөөр зөрүүтэй тооцон төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх иргэдийн санал аваагүй нийт 154.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна.
- Баяндун сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3.0 сая төгрөгийн төсөвтэй "Халуун усны засвар"-ын ажлын төсвөөс 1.5 сая төгрөгийг батлагдсан арга хэмжээнд зарцуулалгүй "Наранбулаг хөгжил" ОНӨААТҮГ-ын урьд оны өрийг төлсөн байна.
- Хөлөнбуйр сум нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27.9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд шилжүүлэн зарцуулсан зэрэг зөрчил гаргасан байна.

#### **6. Өмнөговь аймгийн 2021, 2022 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах арга хэмжээний зардалд зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

- Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системд оруулах мэдээллийг бүрэн оруулаагүй. Тухайлбал: 2019 онд Баян-Овоо сум, Гурвантэс сум, Ханбогд сум, 2020 онд Баян-Овоо сум, Гурвантэс сум, 2021 онд Өмнөговь аймаг, Баян-Овоо сум, Гурвантэс сум, Мандал-Овоо сум, 2022 онд Өмнөговь аймаг, Даланзадгад, Гурвантэс, Мандал-Овоо сум, Номгон сумууд АИТХ-аас баталсан төслийн жагсаалт оруулаагүй бол, 2019 онд Өмнөговь аймаг, Баян-Овоо сум, Гурвантэс сум, Ханбогд сум, 2020 онд Баян-Овоо сум, Гурвантэс сум, 2021 онд Өмнөговь аймаг, Баян-Овоо сум, Гурвантэс сум, Сандал-Овоо сум, 2022 онд Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Баян-Овоо сум, Гурвантэс сум, Мандал-Овоо сум, Номгон сумууд төслийн хэрэгжилтийн мэдээллийг тус тус оруулаагүй байна.

**7.Баян-Өлгий аймгийн 2021, 2022 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй шууд худалдан авалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг ханган ажиллаагүй, Засаг даргын захирамж, гарын үсгийн цохолтыг үндэслэн санхүүжүүлсэн байна. 2021 онд Засаг даргын худалдан авах ажиллагааны 75 төсөл, арга хэмжээг дээрх байдлаар хэрэгжүүлж санхүүжүүлсэн байна. 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн арга хэмжээнээс зөвхөн 1 ажил үйлчилгээ НТШ сонгон шалгаруулалтын аргаар хэрэгжүүлсэн байх ба 2022 оны худалдан авах үйл ажиллагааны 105 төсөл арга хэмжээнээс 81 төсөл арга хэмжээг шууд худалдан авах байдлаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна.
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 10.2-т заасны дагуу аймаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд оруулах ажил хэрэгжээгүй.
- Аймгийн ОНХС-ийн төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дах хэсгийн холбогдох заалтуудаар аймгийн Засаг даргын чиг үүрэгт хамаарах 4,811.2 сая төгрөгийн 158 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн боловч босоо тогтолцоотой зарим байгууллагуудад эд, хогшил тоног төхөөрөмж, урсгал засварын ажилд 2021 онд нийт 127.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

**8.Ховд аймгийн 2021, 2022 оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

1.8.Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчиж орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн санд бүрэн оруулаагүй, эргэн төлөх нөхцөлтэй, хүүтэй зээл олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.3.2 орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх гэснийг мөрдөлгүй нийт 1,010.0 сая төгрөгийн 8 багц төсөл, хөтөлбөр, арга хэмжээг иргэдийн санал авалгүй баталж санхүүжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 4/03 тогтоолоор баталсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад Жаргалант сумын Бугат багийн дулаан дамжуулах төвийн ажилд 200.0 сая төгрөг батлагдсаныг 300.0 сая гэж, Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хөрс сайжруулах ажил 4.4 сая төгрөг батлагдсаныг 4.5 сая гэж тус тус нэмэгдүүлэн гүйцэтгэл гаргасан байна.

Ховд аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 23-ны өдрийн А/833 тоот Захирамжаар "Үйлдвэрлэгч-Ховд" хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэл, ажлын байрны үйл ажиллагааг тасралтгүй явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Михико" ХХК-ны оёдлын үйлдвэрийн "Хонины ноосон дулаан хөнжил" төсөлд 5.0 сая төгрөгийг зарцуулахыг зөвшөөрсөн байна. Тус захирамжийн дагуу 2021 оны 12 сарын 28-ны өдөр Микихо ХХК-ийн Худалдаа хөгжлийн банкны дансанд 5.0 сая төгрөг шилжүүлсэн нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.7.4 "Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа, батлан даалт гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах" гэснийг зөрчсөн байна.

1.9.Орон нутгийн хөгжлийн сангийн -ийн хөрөнгөөр хэрэгжиж буй зарим арга хэмжээ зураг төсвөө батлуулалгүй ажил эхэлснээс гэрээний хугацаа хоцрох, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29.4 "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана" гэж заасныг зөрчин Жаргалант суманд нийтийн халуун ус, сауны цогцолборын барилгын ажил хийх гэрээ байгуулан ажил эхлүүлсэн боловч бараа материалын үнийн өсөлт нөлөөлсөн гэдэг үндэслэлээр барилгын ажил зогсонги байдалд орж өнөөг хүртэл ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 сарын 03-ны өдрийн 3/03 тоот тогтоолоор баталсан Аймгийн 2021 оны төсөв баталсан тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтад Жаргалант суманд нийтийн халуун ус, сауны цогцолборын барилгын ажлыг гүйцэтгэх ажилд 50.0 сая төгрөг, Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 сарын 05-ны өдрийн 4/03 тоот тогтоолоор баталсан төсвийн тодотголоор 2021 оны орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төсөл арга хэмжээнд тухайн ажлын төсөвт өртөг 1,650.0 сая төгрөг, 2021 онд ажил эхлүүлэхэд 450.0 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Ховд аймгийн Засаг даргын орлогч Т.Жаргалсайхан Жаргалант ургамал ХХК-ийн захирал Б.Буяннэмэх нарын хооронд 2021 оны 05 сарын 21-ний өдөр Нийтийн халуун ус, сауны цогцолборын барилгыг эхлүүлэх ажлын ХОАХААА/202104107 тоот гэрээ байгуулсан байна.

Тус гэрээгээр гүйцэтгэгч нь Жаргалант суманд байршилтай тэнхлэгээрээ 30\*15 хүчин чадал бүхий 900 ам.метр талбай, 3240 м3 эзлэхүүнтэй, төмөр бетон карказан хийцтэй цутгамал суурь, 360 мм дүүргэгчтэй, 150 мм ерс хөөсөнцөр дулаалгатай хана, цутгамал хучилттай, 2 давхар барилга угсралтын ажил, өөрийн дулаан хангамжтай, дулааны худгаас цэвэр ус хангамжтай, 35/0.4 квт, ХБ-ээс цахилгаан хангамжтай, /бусад ажил/-ын хамт 2021 оны 05 сарын 24-ний өдөр эхэлж, 2021 оны 07 сарын 09-ний өдөр ашиглалтад оруулахаар тохирчээ.

Гэрээний нийт санхүүжилт 1,584,656,131 төгрөг, санхүүжилтийг 29/71 хувийн харьцаатай олгох ба 2021 онд 29 хувийг олгоно. Гэрээний санхүүжилтийг 2022 онд 71 хувийг олгоно.

Эцсийн санхүүжилт буюу ажлын төлбөрийг албан бичиг, ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, дүгнэлт, ил, далд ажлын акт, хурлын тэмдэглэл, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын болон төсвийн гүйцэтгэл, ажил гүйцэтгэх үе шатны хуваарийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлүүд бүгд албан баталгаажсан, гүйцэтгэсэн ажлын зургийг өнгөтөөр хэвлэмэл, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн 71 хувь буюу 1,134,656,131 төгрөгийн санхүүжилт олгоно. гэж заасан байна.

Гэтэл Жаргалант Ургамал ХХК-аас Ховд аймгийн Засаг даргын орлогч Т.Жаргалсайханд 2021 оны 07 сарын 06-ны өдөр ирүүлсэн хүсэлтэд тухайн ажлыг гүйцэтгэж 2021 оны 07 сарын 10-ны өдөр ашиглалтад оруулах гэрээтэй. Covid-19 цар тахал болон Барилга угсралтын ажлын иж бүрэн зураг өнөөдрийг хүртэл гараагүй байгаа нь ажилд хүндрэл учруулж байгаа тул гэрээг 2021 оны 12 сарын 26-ны өдөр хүртэл сунгаж өгөхийг хүссэн байна. Тухайн хүсэлтийн дагуу гэрээ байгуулсан талууд 2021 оны 07 сарын 20-нд гэрээг 2021 оны 12 сарын 28-ны өдөр хүртэл сунгасан байна. Ингээд 2021 онд санхүүжих 450.0 сая төгрөгийг ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг үндэслэн 2021 оны 09 сарын 06-ны өдөр шилжүүлжээ.

Ажлын гүйцэтгэгч гэрээ сунгах талаар ямар нэг хүсэлт ирээгүй байхад Гэрээ байгуулсан талууд 2022 оны 01 сарын 03-ны өдөр гэрээг 2022 оны 06 сарын 28-ны өдөр хүртэл сунгасан байна. Сунгасан үндэслэлд Захиалагч нь ХОАХААА/202104107 дугаартай гэрээт ажил нь 2021 оны 05 сарын 24-ний өдрөөс 2021 оны 12 сарын 28-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэж хүлээлгэж өгөх байсан боловч гүйцэтгэгчээс ирүүлсэн 2021 оны 07 сарын 08-ны өдрийн 21/26 дугаар албан бичигт Ковид-19 цар тахлын улмаас бараа материалын татан авалт удааширч байгааг үндэслэн гэрээний хугацааг сунгасан тухай дурдсан.

Мөн 2022 оны 02 сарын 14-нд гэрээнд өөрчлөлт оруулж Анхны гэрээний 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт "эцсийн санхүүжилт буюу ажлын төлбөрийг албан бичиг, ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, дүгнэлт, ил, далд ажлын акт, хурлын тэмдэглэл, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын болон төсвийн гүйцэтгэл, ажил гүйцэтгэх үе шатны хуваарийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлүүд бүгд албан баталгаажсан, гүйцэтгэсэн ажлын зургийг өнгөтөөр хэвлэмэл, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн 71 хувь буюу 1,134,656,131 төгрөгийн гэснийг 70 хувь буюу 794,259,291 төгрөгийг явцын санхүүжилтийн гүйцэтгэлээр, 30 хувь буюу 340,396,840 төгрөгийг ажлын төлбөрийг албан бичиг, ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, дүгнэлт, ил, далд ажлын акт, хурлын тэмдэглэл, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын болон төсвийн гүйцэтгэл, ажил гүйцэтгэх үе шатны хуваарийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлүүд бүгд албан баталгаажсан, гүйцэтгэсэн ажлын зургийг өнгөтөөр хэвлэмэл, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн олгоно гэж өөрчилсөн байна.

Гэрээний тус өөрчлөлтийн дагуу 2022 оны 02 сарын 14-нд 295.0 сая, 02 сарын 24-нд 399.1 сая, 08 сарын 15-нд 50.0 сая, 08 сарын 23-нд 100.0 сая, нийт 844.1 сая төгрөг шилжүүлсэн байгаа нь анх байгуулсан гэрээг зөрчсөн байна.

Ажлын зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр хянуулан 2022 оны 02 сарын 07-ны өдөр нийт 2,576.9 сая төгрөгөөр баталгаажуулснаас харахад экспертизээр

баталгаажсан зураг төсөвгүй барилгын ажил гүйцэтгэж байсан болон анхны төсөвт өртөг 992.0 сая төгрөгөөр өссөн байна.

2022 оны 09 сарын 21-ний өдрийн байдлаар нийтийн халуун ус, сауны барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай гэж тайлагнасан байна.

1.10.Орон нутгийн хөгжлийн сангаас 2021 онд зориулалт бусаар нийт 379.1 сая төгрөг зарцуулсан нь тухайн онд төсөл, хөтөлбөрт зарцуулсан дүнгийн 51.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 13 ОНХС-ийн зориулалт бус зарцуулалт 2021 он			/сая төгрөг/	
№	Төрөл	Төсөл хөтөлбөрийн нэр	Мөнгөн дүн	Хувь
1	Зээл	"Үйлдвэрлэгч Ховд" хөтөлбөр	89.6	23.6
2	ТББ-ын томилолтын зардал	"Гурван сэнхэр төвтэй 5 од аялал жуулчлал"-ын хөтөлбөр	19.0	6.0
3	Аудит хийлгэх зардал	"Стандарттай Ховд" хөтөлбөр	24.3	6.4
4	Шинэ Ховд Жаргалант ТҮК ажилчдын цалин	Ногоон хөгжил-ийн хөтөлбөр	46.2	12.2
5	Дэмжлэг	"Эх, хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ" дэд хөтөлбөр	5.0	24.2
6		"Чадварлаг багш, сурагч, оюутан" дэд хөтөлбөр	6.6	
7		"Спортын аварга" хөтөлбөр	34.3	
8		"Олон үндэстэн ястны өв соёл" дэд хөтөлбөр	13.8	
9		"Ахмадаа ачилъя" дэд хөтөлбөр	2.0	
10		"Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр	12.0	
11		"Тайван амгалан Ховдчууд" хөтөлбөр	1.9	
12		"Стандарттай Ховд" хөтөлбөр	0.7	
13		"Үйлдвэрлэгч Ховд" хөтөлбөр	5.4	
14		"Гурван сэнхэр төвтэй 5 од аялал жуулчлал"-ын хөтөлбөр	10.0	
15	Урамшуулал	Чадварлаг багш, сурагч, оюутан дэд хөтөлбөр	60.6	16.0
16	тэтгэлэг	"Чадварлаг багш, сурагч, оюутан" дэд хөтөлбөр	11.0	2.9
17	Малын халдваргүйтгэлийн бэлдмэл, вакцин, ариутгал	Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах дэд хөтөлбөр	36.7	9.7
Нийт			379.1	100%

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 2021 онд зээл 89.6 сая төгрөг, дэмжлэг 91.7 сая төгрөг, урамшуулал 60.6 сая төгрөг, тэтгэлэг 11.0 сая төгрөг, "Цаст алтайн угсаатан аялал жуулчлалын холбоо" НҮТББ-ын зардалд 19.0 сая төгрөг, Шинэ Ховд Жаргалант ТҮК ажилчдын цалин 46.2 сая төгрөг, Малын халдваргүйтгэлийн бэлдмэл, вакцин, ариутгалын зардалд 36.7 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7 дахь заалт "улс төрийн нам, төрийн бус байгууллагын зардал гаргах, зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа, аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулалд зарцуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

1.11.Орон нутгийн хөгжлийн сангаас 2022 онд зориулалт бусаар нийт 201.5 сая төгрөг зарцуулсан нь нийт төсөл, хөтөлбөрийн 31.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 14 Орон нутгийн хөгжлийн сангийн зориулалт бус зарцуулалт 2022 он  
/сая төгрөг/

Төрөл	Төсөл хөтөлбөрийн нэр	мөнгөн дүн	Хувь
Дэмжлэг	Эрүүл мэндийн салбарын дэд хөтөлбөрүүд /"Эрүүл иргэн", "Эх, хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ", "Чадварлаг эмч, мэргэжилтэн, "Эрүүл эр хүн"/	17.0	69.1
	Боловсролын салбарын дэд хөтөлбөрүүд /"Чанартай боловсрол", "Тогтвортой хөгжлийн боловсрол", "Монгол хэл бичиг", "Чадварлаг багш, сурагч, оюутан"	10.4	
	Спортын салбарын дэд хөтөлбөрүүд /"Спортын аварга", "Дугуйтай Ховд"/	73.5	
	Соёлын салбарын дэд хөтөлбөрүүд /"Олон үндэстэн ястны өв соёл", "Оюун түлхүүр"/	12.9	
	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд хөтөлбөрүүд /"Монгол гэр бүл", "Ахмадаа ачилъя", "Залуучуудын хөгжил", "Жендерийн тэгш байдлыг хангах",	13.1	
	Хууль эрх зүйн салбарын дэд хөтөлбөрүүд /"Тайван амгалан Ховдчууд", "Иргэдийн эрх зүйн боловсрол олгох"/	1.4	
	Байгаль орчин, аялал жуулчлал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын дэд хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүд /"Ногоон хөгжил", "Гурван сэнхэр төвтэй 5 од аялал жуулчлал",	11.0	
Тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд хөтөлбөрүүд /"Монгол гэр бүл", "Ахмадаа ачилъя", "Залуучуудын хөгжил", "Жендерийн тэгш байдлыг хангах",	6.0	2.9
Урамшуулал	Эрүүл мэндийн салбарын дэд хөтөлбөрүүд /"Эрүүл иргэн", "Эх, хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ", "Чадварлаг эмч, мэргэжилтэн, "Эрүүл эр хүн"/	47.0	28.0
	Боловсролын салбарын дэд хөтөлбөрүүд /"Чанартай боловсрол", "Тогтвортой хөгжлийн боловсрол", "Монгол хэл бичиг", "Чадварлаг багш, сурагч, оюутан"	3.5	
	Спортын салбарын дэд хөтөлбөрүүд /"Спортын аварга", "Дугуйтай Ховд"/	1.3	
	Соёлын салбарын дэд хөтөлбөрүүд /"Олон үндэстэн ястны өв соёл", "Оюун түлхүүр"/	1.5	
	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд хөтөлбөрүүд /"Монгол гэр бүл", "Ахмадаа ачилъя", "Залуучуудын хөгжил", "Жендерийн тэгш байдлыг хангах",	1.0	
	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх дэд хөтөлбөрүүд /"Цахим Ховд", "Стандарттай Ховд", "Хариуцлагатай тунгалаг төр", "Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжил"/	1.9	
Нийт		201.5	100%

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 2022 онд дэмжлэг 139.3 сая төгрөг, урамшуулал 56.2 сая төгрөг, тусламжид 6 сая төгрөг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7 дахь заалт улс төрийн нам, төрийн бус байгууллагын зардал, зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа, аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулалд зарцуулахыг хориглосон гэснийг зөрчсөн байна.

12. *Жаргалант сум нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийг хэт жижиглэх замаар тендер зарлалгүй шууд худалдан авалт зохион байгуулж байгаа нь хөгжлийн томоохон хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлаж байна.*

Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас 2022 оны эхний хагас жилд нийт 48 ажилд 1,026.4 сая зарцуулсны дийлэнхийг 20.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөг бүхий ажлууд хийгдсэн ба олон ястны өв соёлын цогцолборын тохижилт/цамбагарав баг/, камержуулалт хийх, ногоон байгууламжийн хайс хашлага хийх авах, зуны сувилал, ахлах ангийн суралцагчдын нөлөөллийн арга хэмжээ, хоггүй Ховд хөтөлбөр худаг, мал угаалгын ванн засвар, худаг ус гаргах зэрэг ажлуудад харьцуулалтын аргаар болон шууд гэрээ байгуулан санхүүжүүлж ажилласан байна.

Сумын ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхдээ сумын Засаг даргын захирамжаар нэг арга хэмжээний зардлыг хэд хуваан шийдвэр гаргаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн байна.

Төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулж буй хөрөнгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7 дахь заалтыг зөрчсөн асуудлыг шалгалтын хугацаанд баримтыг бүдүүлүүлэн зөрчлийг арилгасан болно.

**9. Архангай аймгийн 2021, 2022 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Архангай аймгийн Эрдэнэбулган суманд аймгийн Орон нутгийн сангийн хөрөнгөөр Ноос, ноолуур угаах үйлдвэр байгуулахаар 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн Засаг даргатай байгуулсан ААОНӨГ/2018011001/33 дугаартай гэрээт ажил хэрэгжээгүй тул Тэрхийн ундраа ХХК-аас тоног төхөөрөмжийн урьдчилгаа нэрээр олгосон 187.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг гаргуулахаар 3 шатны шүүхийн шийдвэр гаргуулж, Монгол улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 001/ШХТ2022/00364 дүгээр тогтоолоор эцэслэн шийдвэрлэгджээ. Гэтэл дээрх төлбөрийг 2023 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар Тэрхийн ундраа ХХК-аас гаргуулаагүй, аймгийн төсвийн орлогод оруулаагүй байна.

**10. Дорнод аймгийн 2021, 2022 төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс төсөв хэлэлцэх явцад иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй, төслийг хэрэгжүүлэгчээс санал оруулаагүй, тооцоо судалгаагүй төсөл, арга хэмжээг хэлэлцүүлэн баталж байна.

- Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг ашиглалтад оруулах, хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан гишүүд нь ажлын гүйцэтгэлийг ажлын зураг төсөл, тендерийн баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу байгаа эсэх, баримт бичигт заасан шаардлагыг хангасан эсэхийг бүрэн хянадаггүй, техникийн тодорхойлолтод нийцээгүй байхад ашиглалтад хүлээн авах зэргээр хууль тогтоомжоос давсан эрх мэдлийг хэрэгжүүлсэн.

**11. Өвөрхангай аймгийн 2023, 2024 төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Аймгийн иргэдийн хурлын тогтоолоор 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 80 хувьд иргэдийн саналыг авч, эрэмбэлээгүй байна.

- Өвөрхангай аймгийн “Эдийн засгийн хөгжлийн загварчлал боловсруулах” ажлыг 2023 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн дотор гүйцэтгэхээр 36.0 сая төгрөгийн СА-2023/ОНТ-01 дугаартай гэрээ

байгуулжээ. Гүйцэтгэгч талаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гэрээний хугацааг сунгасан байна. Гэрээ дахин сунгагдаагүй, гэрээт ажлыг бүрэн дуусгаж захиалагч талд актаар хүлээлгэж өгөөгүй байна. Тус гэрээний 2.5-д “санхүүжилтийг гүйцэтгэгч талд урьдчилгаанд үнийн дүнгийн 50 хувийг шилжүүлэх бөгөөд гэрээт ажлаа бүрэн гүйцэтгэж дуусган, захиалагч талд актаар хүлээлгэн өгсний дараа үлдсэн 50 хувийн санхүүжилтийг гүйцэтгэгч талд шилжүүлнэ” гэж заасан боловч урьдчилгаа 18.0 сая төгрөгийг 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр, харин ажлын гүйцэтгэл бүрэн дуусгаж актаар хүлээлгэж өгөөгүй байхад 14.0 сая төгрөгийг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шилжүүлсэн байна.

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд Бат-Өлзий, Баянгол, Уянга сумуудад нийт 540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 тонн гүн хөлдөөгчтэй мал нядалгааны цех баригдсан. Тус барилгыг ашиглалтад хүлээн авах тухай Засаг даргын захирамжаар байгуулагдсан комисс ажиллаж, гүйцэтгэгч байгууллагад өгсөн үүрэг даалгавар биелэгдээгүй, тог цахилгаан шийдэгдээгүй зэргээс шалтгаалж хөрөнгө одоог хүртэл ашиглалтгүй байна.

- Арвайхээр суманд Эко ариун цэврийн байгууламж хийхээр Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 532.8 сая төгрөг сумын орон нутгийн хөгжлийн сангаас 180.0 сая төгрөг нийт 693.0 сая төгрөгөөр гүйцэтгэгчээр шалгарсан “Онон нинж” ХХК-тай гэрээ байгуулсан. Энэ гэрээнд нэг бүрийн үнэ нь 3,500.0 мянган төгрөгийн үнэтэй 266 ширхэг эко ариун цэврийн байгууламж барихаар тохирсон байсан 3,500.0 мянган төгрөгийн 25% буюу 875.0 мянган төгрөгийг айл өрхөөр, 75% буюу 2,625.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас төвлөрсөн хөрөнгөөр санхүүжүүлэхэд тохирсон байна. Гүйцэтгэгчийн тал гэрээгээр хүлээсэн үүргээ 2024 оны 11 дүгээр сарын 1-нд дуусгахаар тохирсон боловч 2024 оны 10 дугаар сарын 28-ний 18 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг харгалзан 2025 оны 8 дугаар сарын 01-ны хүртэл сунгасан. Гэрээнд хийгдэх 266 эко ариун цэврийн байгууламжаас 130 нь техникийн чанарын шаардлага хангаагүй, 25 иргэний тушаасан мөнгийг буцаасан, 24 нь хад чулуутай шалтгаанаар хийгдээгүй, 87 нь ажлыг эхлээгүй байна. Гэтэл гэрээний ажлын гүйцэтгэл 49% тай байхад нийт санхүүжилтийн 64.6 хувь буюу 446.5 сая төгрөгийг гүйцэтгэгч талд шилжүүлсэн байна.

Тус ажлын гүйцэтгэл чанарт хяналт тавих аймгийн Засаг даргын 2025 оны А/315 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, эко ариун цэврийн байгууламжийг газар дээр нь очиж үзэхэд 100 хувь хийгдсэн байгууламж байхгүй, мөн ажлын зургийн тоо хэмжээ болон эко ариун цэврийн байгууламж хийх айл өрхийн тооноос хассан, ашиглаж буй материал чанаргүй, эко ариун цэврийн байгууламж угсралтын ажилд захиалагчийн хяналтын зардлыг норм дүрмийн дагуу хяналт хийлгэж чанар стандарт хангуулж ажиллахыг зөвлөсний дагуу захиалагч Арвайхээр сумын ЗДТГ нь хяналт тавьж ажиллаагүй, гүйцэтгэгч Отгон нинж ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

- 2024 онд Орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй эко ариун цэврийн байгууламжийг айл өрхүүдэд зориулж 532.8 сая төгрөг, Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүү 340.0 сая төгрөг нийт 872.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

**12. Баянхонгор аймгийн 2023, 2024 төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар:**

- Орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй айл өрхийн хашаа гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулах, айл өрхүүдэд эко нойл нэмэгдүүлэхээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд 250,130.0 мянган төгрөг, 2024 онд 292,093.4 мянган төгрөг, нийт 542,223.4 мянган төгрөгийн өртөг бүхий 6 төсөл хөтөлбөр арга хэмжээг аж ахуйн нэгж байгууллагуудаар гүйцэтгүүлэн 492,223.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.3.2 дахь заалтыг зөрчсөнд Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.
- Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/384 дүгээр захирамжаар Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэхээр 200,000.0 мянган төгрөгийг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах үүрэг өгсөн байхад тус төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тендерийн худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг 12 хэсэг болгон хуваан, гэрээний дүнг 10,000.0–20,000.0 мянган төгрөгийн хооронд иргэдтэй байгуулан гүйцэтгүүлсэн байна.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилах аргачлалыг 2012 оноос анх баталж үүнээс хойш 4 удаа өөрчилсөн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийг тогтоосон итгэлцүүрүүдэд үндэслэн хуваарилдаг бөгөөд Хуулийн 59.5 дахь хэсэгт орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хуваарилалтын аргачлалыг батлах, шинэчлэх эрхийг Засгийн газарт олгосон байдаг.

Энэ хүрээнд Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг тооцох аргачлалыг анх баталж, 2017 оны 230 дугаар тогтоол, 2023 оны 457 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталж байсан.

Түүнчлэн, Төсвийн тухай хуульд 2021 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу 59.7 дахь хэсгийг нэмж, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг орон нутагт илүү хөрөнгө хуваарилах эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хуваарилалтын аргачлал болон илтгэлцүүрүүдэд орсон өөрчлөлтийг дараах үе шатуудаар ангилан танилцуулж байна.

**I. Орон нутгийн хөгжлийн сангийн 2013-2016 оны хуваарилалтын зарчим**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилах тогтолцоо нь орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, төсвийн ялгааг бууруулах, нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор 2013 оноос хэрэгжиж эхэлсэн. Тодруулбал, орон нутгийн хөгжлийн тэгш бус байдлыг бууруулах, хүн амын хэрэгцээг харгалзах, газарзүйн онцлогийг харгалзан санхүүжүүлэх, мөн орон

нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэх урамшуулал бий болгох гэсэн дөрвөн үндсэн бодлогын зорилгыг зэрэг хэрэгжүүлэхэд чиглэж байсан.

Энэ нь төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын нэг гол хэрэгсэл болсон бөгөөд энэ хугацаанд хуваарилалтын аргачлалыг тогтвортой болгох, улс төрийн нөлөөллийг багасгах, хөрөнгө хуваарилах шалгуурыг хуульд тодорхой тусгах, орон нутгийн хөгжлийн бодит хэрэгцээнд тулгуурласан санхүүжилтийг бий болгох зарчмыг баримталж байсан.

2013-2016 онд дараах илтгэлцүүрүүдэд үндэслэн хуваарилж байсан. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн индекс
2. Хүн амын тоо
3. Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ
4. Орон нутгийн татварын идэвх санаачилга

### **Орон нутгийн хөгжлийн индекс**

Энэ үзүүлэлт нь тухайн орон нутгийн хөгжлийн түвшин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг илэрхийлэх цогц индекс юм. Үүнд:

- Дэд бүтцийн хангамж
- Хүрээлэн байгаа байгаль орчин
- Нийгэм, эдийн засгийн байдал
- Хөгжлийн нөөц, давуу тал
- Хөдөө аж ахуй гэсэн үзүүлэлтэд үндэслэн тооцож байсан.

Хөгжил харьцангуй сул, үйлчилгээний хүртээмж доогуур орон нутагт илүү их хөрөнгө хуваарилж, бүс нутгийн хөгжлийн ялгааг бууруулах зорилготой байсан.

### **Хүн амын тоо**

Энэхүү шалгуур нь тухайн орон нутгийн оршин суугаа хүн амын тоонд үндэслэж байв. Хүн амын тооноос шалтгаалж орон нутагт нийтийн үйлчилгээний эрэлт өндөр, сургууль, цэцэрлэг, зам, гэрэлтүүлэг зэрэг нийтийн зориулалттай хөрөнгө оруулалтын хэрэгцээ их байдаг. Иймээс хүн амын тоо өсөх тусам орон нутгийн хөгжлийн сангаас хүртэх хөрөнгийн хэмжээ нэмэгдэх зарчим үйлчилдэг.

### **Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ**

Энэ шалгуур нь Монгол Улсын газарзүйн онцлогийг харгалзан боловсруулагдсан. Үүнд:

- хүн ам сийрэг суурьшсан байдал
- аймаг, сумын төвөөс алслагдсан байршил
- өргөн удам нутаг дэвсгэртэй байх
- үйлчилгээ хүргэх өртөг өндөр байх зэрэг хүчин зүйлсийг тооцдог байв

Алслагдсан болон том газар нутагтай орон нутгийн үйлчилгээний зардал харьцангуй өндөр байдаг тул үүнийг санхүүжилтээр нөхөх зорилготой байсан.

### **Орон нутгийн татварын идэвх санаачилга**

Энэ нь тухайн орон нутгийн өөрийн орлогыг бүрдүүлэх хүчин чармайлтыг үнэлэх үзүүлэлт байсан. Үүнд:

- орон нутгийн татварын орлогын биелэлт

- татварын бааз суурийг өргөжүүлэх ажиллагаа
- татвар хураалтын үр ашиг
- орлогын төлөвлөлтийн сахилга бат зэрэг үзүүлэлтүүдийг харгалздаг байв.

Орон нутгийн удирдлагыг зөвхөн улсаас олгох шилжүүлэгт найдах бус, өөрийн орлогыг нэмэгдүүлэх идэвхийг дэмжих зорилготой байсан.

Ингэснээр хуваарилалтын тогтолцоо нь зөвхөн хүн амын тоонд бус, хөгжлийн түвшин, газарзүйн онцлог, санхүүгийн сахилга батыг хамтад нь үнэлсэн тэнцвэржүүлэх санхүүжилтийн механизм болж байсан юм.

## **II. Орон нутгийн хөгжлийн сангийн 2017-2021 оны хуваарилалтын зарчим**

Энэ хугацаанд хуваарилалтын үндсэн аргачлал тогтвортой хадгалагдсан бөгөөд дараах бодлогын чиглэлүүд илүү тодорхой болсон. Үүнд:

- Иргэдийн оролцоотой төлөвлөх тогтолцоог бэхжүүлэх
- Хөрөнгө оруулалтыг хөгжлийн хэрэгцээ, үйлчилгээний хүртээмжтэй уялдуулах
- Орон нутгийн төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх
- Санхүүгийн төвлөрлийг сааруулах бодлогыг үргэлжлүүлэх
- Орон нутгийн хөгжлийн ялгааг бууруулах зорилтот санхүүжилтийг хадгалах

Мөн энэ хугацаанд иргэдийн нийтийн хурлын оролцоотойгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх, сонгох үйл явцыг илүү боловсронгуй болгож, хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан.

Хөрөнгө хуваарилах аргачлал нь суурь зарчмыг хадгалсан боловч шалгуур үзүүлэлтүүдийг илүү оновчтой болгож, "хүн амын нягтрал, алслалт" гэсэн нэгдсэн үзүүлэлтээр газарзүйн хүчин зүйлийг тооцох болсон нь гол өөрчлөлт байсан. Орон нутгийн хөгжлийн ялгааг бууруулах, хүн амын хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийг дэмжих, мөн орон нутгийн санхүүгийн бие даасан байдал, татварын идэвх санаачилгыг урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх үндсэн механизм хэвээр үргэлжилсэн.

2017-2021 онд дараах илтгэлцүүрүүдэд үндэслэн хуваарилж байсан. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн индекс
2. Хүн амын тоо
3. Хүн амын нягтрал, алслалт
4. Орон нутгийн татварын идэвх санаачилга

## **III. Орон нутгийн хөгжлийн сангийн 2021-2023 оны хуваарилалтын зарчим**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хуваарилах аргачлалд томоохон өөрчлөлт орж, өмнө нь ашиглаж байсан "орон нутгийн татварын идэвх санаачилга" гэсэн итгэлцүүрийг хассан. Энэхүү өөрчлөлт нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдан хэрэгжсэн бөгөөд 2022 оны төсвөөс эхлэн бодитоор мөрдөгдөж эхэлсэн бөгөөд хуваарилалтыг орон

нутгийн хөгжлийн бодит хэрэгцээ, хүн ам, газарзүйн онцлогт илүү тулгуурлах болсон.

Мөн Төсвийн тухай хуульд 59.7 дахь хэсгийг шинээр нэмж, уул уурхайн орлого төвлөрүүлж буй аймагт эх үүсвэрийн тодорхой хувийг дахин хуваарилах шинэ зохицуулалтыг бий болгосон.

2021-2023 онд дараах илтгэлцүүрүүдэд үндэслэн хуваарилж байсан. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн индекс
2. Хүн амын тоо
3. Хүн амын нягтрал, алслалт

Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр өмнө нь хэрэглэж байсан "орон нутгийн татварын идэвх санаачилга" гэсэн итгэлцүүрийг хассан. Энэ өөрчлөлтийн үндсэн шалтгаан нь орон нутгийн төсвийн орлогын шинэ тогтолцоог бүрдүүлсэнтэй холбоотой юм. Тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тодорхой хувийг аймаг, нийслэлд үлдээх болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орон нутагт үлдэх орлогыг нэмэгдүүлэх зэрэг шинэ зохицуулалтууд хэрэгжсэн. Иймээс татварын идэвх санаачилгыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хуваарилах шалгуур болгон ашиглах шаардлага буурсан гэж үзэж итгэлцүүрээс хассан.

Төсвийн тухай хуульд 59.7 дахь хэсэг нэмэгдэж, хэрэгжиж эхэлснээр уул уурхайн орлого төвлөрүүлдэг аймагт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн эх үүсвэрийн тодорхой хувийг буцаан хуваарилах тогтолцоо бүрдэж, орон нутгийн хөгжлийн санхүүжилтийг тогтвортой болгоход чиглэсэн шинэ бодлогын хэрэгсэл болсон.

Энэхүү зохицуулалтын зорилго нь ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэлийн улмаас орон нутагт үүсэж буй дэд бүтэц, байгаль орчин, нийгмийн үйлчилгээний ачааллыг санхүүгийн хувьд нөхөх, уул уурхайн орлого бүрдүүлж буй аймагт илүү тогтвортой санхүүгийн эх үүсвэр бий болгох, тухайн орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн.

Өөрөөр хэлбэл, өмнө нь татварын идэвх санаачилгаар дамжуулан орон нутгийг урамшуулдаг байсан бол 2021 оны шинэчлэлээр уул уурхайгаас бий болсон орлогыг эх үүсвэртэй нь уялдуулан тухайн орон нутагт буцаан хуваарилах шинэ механизм бий болсон.

#### **IV. Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оноос мөрдөж буй хуваарилалтын зарчим**

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсанаар орон нутгийн хөгжлийн сантай холбоотой томоохон шинэчлэлүүд хэрэгжиж эхэлсэн. Энэхүү өөрчлөлтийн зорилго нь ОНХС-гийн хөрөнгийн хуваарилалтыг илүү оновчтой, үр дүнд суурилсан, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан тогтолцоонд шилжүүлэхэд чиглэсэн.

#### **Итгэлцүүрийн шинэчлэл**

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг дараах итгэлцүүрээр тооцохоор шинэчилсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн индекс
- Хүн амын тоо
- Нутаг дэвсгэрийн хэмжээ
- Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ

### **Нутаг дэвсгэрийн хэмжээ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалттай нийцүүлэх зорилгоор "хүн амын нягтрал, алслалт" гэсэн итгэлцүүрийг "нутаг дэвсгэрийн хэмжээ" гэсэн итгэлцүүрээр сольсон. Энэ нь Монгол Улсын өргөн уудам газар нутаг, төрийн үйлчилгээ хүргэх зардлын ялгааг илүү бодитой тусгах зорилготой байсан бөгөөд том газар нутагтай аймагт үйлчилгээ үзүүлэх, авто зам, инженерийн дэд бүтэц, байгаль орчны хамгаалалт зэрэг төсвийн зардал өндөр байдгийг харгалзан үзсэн.

### **Орон нутгийн хөгжлийн индексэд үндэслэн хөрөнгө хуваарилах зарчмыг шинэчилсэн**

Өмнөх зохицуулалтаар орон нутгийн хөгжлийн индекс нь хөгжлийн түвшин доогуур аймагт илүү их хөрөнгө хуваарилах буюу тэнцвэржүүлэх үүрэгтэй байсан. Харин 2023 онд хийсэн аргачлалын өөрчлөлтөөр хөгжлийн индексийг гүйцэтгэл, хөгжлийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлт болгон ашиглах чиглэл рүү шилжсэн.

Ингэснээр хөгжлийн индекс өндөр буюу хөгжлийн түвшин сайжирсан аймагт тухайн үзүүлэлтийн дагуу тооцох хөрөнгийн хэмжээ өсөх боломжтой болсон. Энэ нь хөгжлийн бодлогоо үр дүнтэй хэрэгжүүлсэн, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан, хөгжлийн индексээ ахиулсан аймгуудыг санхүүгийн хувьд урамшуулах шинэ тогтолцоо юм.

### **Төсвийн тухай хуулийн 59.7 дахь хэсэгт орсон шинэчлэл**

Орон нутагт уул уурхайн үйл ажиллагааг дэмжих, уул уурхайн олборлолт хийгдэж буй орон нутагт түлхүү хуваарилах бодлогыг баримталж, Төсвийн тухай хуулийн 59.7-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс төвлөрсөн орлогыг орон нутагт дахин хуваарилдаг хувь, хэмжээг нэмэгдүүлсэн.

Тус зохицуулалт нь ашигт малтмалын орлого төвлөрүүлдэг аймгуудыг тухайн эх үүсвэрт оруулж буй хувь хэмжээгээр нь ангилан ялгамжтай хуваарилах, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл ихтэй аймагт илүү бодитой санхүүгийн дэмжлэг үзүүлэх, байгалийн баялгийн үр өгөөжийг тухайн орон нутагт илүү хүртээмжтэй хуваарилах эрх зүйн үндсийг боловсронгуй болгосноороо ач холбогдолтой юм.

### **Сум, дүүрэгт хуваарилагдах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шинэчлэл**

Орон нутгийн иргэдийн санал, санаачилга, хэрэгцээ шаардлагад үндэслэн зарцуулагддаг хөрөнгийн хэмжээг сум, дүүргийн түвшинд нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтын тогтолцоонд өөрчлөлт оруулсан.

Тодруулбал, аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийн хэмжээг өмнөхөөс нэмэгдүүлж, нийт хөрөнгийн 60 хувийг сум, дүүрэгт шилжүүлэхээр зохицуулсан. Ингэснээр иргэд өөрсдийн амьдрах орчны тулгамдсан

асуудлыг шийдвэрлэх, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд илүү их санхүүгийн боломж бүрдсэн.

Мөн уул уурхай, газрын тосны олборлолт хийгдэж байгаа сумдад илүү хөрөнгө хуваарилах зорилгоор сумдын орон нутгийн хөгжлийн сангийн итгэлцүүрт уул уурхайн болон газрын тосны итгэлцүүрийг нэмсэн. Энэхүү өөрчлөлт нь байгалийн баялгийн олборлолтын нөлөөлөлд өртөж буй орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, хөгжлийн үр өгөөжийг илүү шударга, тэнцвэртэй хүртээхэд чиглэсэн.

5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээг иргэдийн оролцоонд тулгуурлан жил бүрийн 1–6 дугаар сард санал асуулгын хуудас, бүлгийн хэлэлцүүлэг, цахим гэсэн гурван хэлбэрээр иргэдээс санал авдаг. Ирсэн саналыг Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу байгуулагдсан ажлын хэсэг хянан эрэмбэлж, хамгийн өндөр эрэмбэтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх жагсаалтад оруулан Засаг даргад хүргүүлдэг. Энэхүү тогтолцооны хэрэгжилтийг Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээний хүрээнд Удирдлага мэдээллийн систем (УМС)-ээр дамжуулан үнэлдэг бөгөөд уг үнэлгээнд иргэдийн оролцооны бүлэг үзүүлэлтийг тусгайлан оруулсан. Ингэснээр тус системд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн сум тус бүрийн хэмжээнд иргэдээс ирсэн саналыг тогтоосон аргачлалын дагуу эрэмбэлсэн байдал мөн санхүүжүүлэх жагсаалтад саналууд тусгагдсан эсэхэд үнэлгээ хийдэг.

Аймгийн түвшний үнэлгээний ажлын хэсэг УМС-ээр тухайн аймгийн бүх сумдад хийж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймгийн хийсэн үнэлгээг хянаж, баталгаажуулан болзол хангасан сумдын жагсаалтыг гаргаж, үнэлгээний дагуу олгох санхүүжилтийг дараа жилийн төсөвт тусгадаг.

6. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлэх цахим системийн өнөөгийн байдал, иргэдийн бодитой оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах байдлаар ажиллаж байна.

### **Ил тод байдал**

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.3.9 Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 11 дүгээр хавсралтад заасан агуулгын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, сарын гүйцэтгэл хэрэгжилтийн талаарх мэдээллийг сар бүрийн 8-ны өдрийн дотор Сангийн яам тогтмол мэдээлдэг.

### **Цахим систем**

Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд нээлттэй байлгах цахим мэдээллийн систем болох удирдлага мэдээллийн

систем (УМС) болон гар утасны аппликейшныг хөгжүүлсэн. Тус системээр дамжуулан иргэд орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөв, иргэдийн саналд үндэслэн батлагдсан төсөл, арга хэмжээний мэдээлэл, төслүүдийн эрэмбэлэлт, хэрэгжилтийн явц болон санхүүжилтийн мэдээлэлтэй танилцах боломжтой.


Удирдлагын мэдээллийн систем (УМС) нь хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилт, төлөвлөлтөөс эхлээд хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хүртэлх бүхий л үе шатны мэдээллийг цахим хэлбэрээр удирдах, хянах боломжийг бүрдүүлсэн нэгдсэн систем юм.

### **Иргэдийн оролцоо**

Иргэдийн оролцоог нэмэгдүүлж, санал өгөх үйл явцыг хялбар, хүртээмжтэй болгох зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн системийг (УМС) үндэсний цахим үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia" порталтай холбож, нэвтрэлтийг "ДАН" танилт, нэвтрэлтийн нэгдсэн системээр баталгаажуулах сервисийг хөгжүүлсэн. Үүний үр дүнд орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэд цахим хэлбэрээр санал илгээх боломж бүрдэж, оролцооны ил тод байдал сайжирсан. Цахим саналын тогтолцоо 2023 оноос эхэлсэн бөгөөд иргэд жил бүрийн 1–6 дугаар сарын хугацаанд "E-Mongolia" портал, гар утасны аппликейшн болон орон нутгийн хөгжлийн сангийн олон нийтэд зориулсан цахим систем, аппликейшнээр дамжуулан саналаа илгээх боломжтой болсон.

Цахим саналын тогтолцоо хэрэгжиж эхэлснээс хойш иргэдийн оролцоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, 2023 онд 220,656, 2024 онд 358,560, 2025 онд 239,282, 2026 онд 405,433 иргэн цахимаар санал илгээсэн байна. Энэхүү үзүүлэлт нь орон нутгийн хөгжлийн сангийн цахим тогтолцоо иргэдэд хүртээмжтэй болж, иргэдийн оролцоо нэмэгдсэнийг харуулж байна.

Хүндэтгэсэн,



З.МЭНДСАЙХАН

1. 2013-2026 ОНООС ХОЙШ ОРОН НУТГИЙН ХОГЖЛИЙН САЦУЛСЫН ТӨСВООС ЖИЛ БҮР АЙМАГ, НИЙСГЭДД ХУВААРИЛСАН ХОРОНГО

Хавсралт 1

/сая төг/

№	Аймаг	2013		2014		2015		2016		2017		2018		2019	
		Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл
1	Архангай	8,704.1	8,123.5	11,073.8	8,039.0	5,049.2	4,189.9	3,179.9	3,179.9	1,987.2	1,987.2	3,597.7	3,597.7	5,489.9	5,485.0
2	Баян-Өлгий	7,646.6	7,063.2	9,638.8	6,936.0	4,588.6	3,816.3	3,260.1	3,260.1	1,654.4	1,654.4	4,940.7	4,940.7	7,281.9	7,202.6
3	Баянхонгор	10,176.2	9,605.8	12,789.6	9,482.8	5,918.7	4,888.2	4,737.8	4,737.8	2,163.3	2,163.3	3,795.7	3,795.7	6,485.9	6,282.4
4	Булган	7,353.9	6,482.8	9,253.6	6,864.6	4,338.6	3,588.9	3,550.5	3,550.5	1,745.0	1,745.0	2,312.2	2,312.2	3,570.1	3,515.4
5	Говь-Алтай	9,959.8	8,504.3	12,373.3	9,649.9	5,733.8	4,732.1	5,693.7	5,693.7	2,185.0	2,185.0	3,399.3	3,399.3	6,253.5	6,645.8
6	Дорноговь	8,130.4	7,616.5	10,146.8	7,435.3	4,755.8	3,935.7	5,579.9	5,579.9	2,307.0	2,307.0	3,275.6	3,275.6	6,795.9	5,544.1
7	Дорнод	8,907.9	7,804.4	11,184.5	8,379.2	5,173.1	4,282.9	4,140.6	4,140.6	2,084.1	2,084.1	3,650.4	3,650.4	6,104.7	5,876.3
8	Дундговь	8,023.4	7,187.7	9,947.5	7,390.9	4,581.4	3,777.8	4,114.7	4,114.7	1,846.8	1,846.8	2,075.2	2,075.2	3,627.5	3,313.6
9	Завхан	8,218.4	7,857.5	10,347.6	7,557.4	4,841.0	4,006.8	4,185.8	4,185.8	1,708.7	1,708.7	3,471.2	3,471.2	5,334.1	5,152.8
10	Өвөрхангай	9,586.1	8,330.3	12,263.9	9,350.2	5,557.4	4,615.8	3,444.4	3,444.4	2,253.9	2,253.9	4,374.3	4,374.3	6,680.4	6,660.5
11	Өмнөговь	9,738.0	8,317.5	12,185.4	9,372.0	5,649.3	4,674.9	21,515.0	21,515.0	3,190.3	3,190.3	3,387.7	3,387.7	6,402.0	5,886.4
12	Сүхбаатар	8,396.9	8,364.6	10,495.1	7,696.5	4,856.4	4,012.5	7,681.2	7,681.2	1,554.8	1,554.8	2,666.1	2,666.1	5,304.8	4,345.6
13	Сэлэнгэ	7,174.2	6,666.9	9,215.9	6,634.3	4,450.1	3,709.7	4,887.3	4,887.3	2,139.6	2,139.6	3,838.7	3,838.7	5,825.4	5,795.6
14	Төв	7,621.7	6,924.1	9,618.2	6,922.9	4,594.2	3,817.1	6,300.9	6,300.9	1,808.2	1,808.2	3,211.9	3,211.9	5,094.7	4,936.7
15	Увс	8,095.2	7,517.7	10,132.0	7,774.4	4,693.1	3,890.9	3,040.6	3,040.6	1,709.8	1,709.8	4,227.7	4,227.7	6,446.2	6,204.9
16	Ховд	8,792.9	7,910.8	11,002.6	8,095.4	5,235.1	4,338.4	3,664.1	3,664.1	1,778.3	1,778.3	4,423.2	4,423.2	6,667.9	6,536.8
17	Хөвсгөл	9,356.1	8,161.8	11,997.6	8,927.2	5,492.9	4,573.2	3,395.6	3,395.6	2,186.4	2,186.4	5,455.4	5,455.4	8,407.4	8,387.2
18	Хэнтий	8,332.4	8,282.5	10,461.5	8,445.6	4,946.1	4,094.8	4,417.2	4,417.2	1,995.4	1,995.4	3,110.7	3,110.7	5,052.7	4,830.1
19	Дархан-Уул	6,915.5	6,543.6	8,549.0	6,096.2	4,241.5	3,535.5	3,295.3	3,295.3	1,773.3	1,773.3	2,933.2	2,933.2	4,661.9	4,659.2
20	Улаанбаатар	35,030.6	27,766.3	46,330.7	32,137.6	24,576.8	20,960.0	14,393.7	14,393.7	11,822.6	11,822.6	16,258.5	16,258.5	26,509.2	26,506.9
21	Орхон	7,511.1	7,015.3	9,455.3	6,774.4	4,577.2	3,812.3	3,562.0	3,562.0	1,941.3	1,941.3	3,504.9	3,504.9	4,972.5	4,972.5
22	Говьсүмбэр	5,940.4	5,438.2	7,328.8	5,425.0	3,308.8	2,721.2	2,227.4	2,227.4	1,178.1	1,178.1	644.6	644.6	926.3	915.3
Нийт дүн		209,613.8	187,465.4	265,791.3	195,387.0	127,159.0	105,984.8	120,267.7	120,267.7	53,013.5	53,013.5	88,555.0	88,555.0	143,874.7	138,645.5

№	Аймгууд	2020		2021		2022		2023		2024		2025		2026
		Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан
1	Архангай	4,778.4	4,338.5	6,440.9	6,440.9	6,815.9	6,815.8	10,740.4	10,571.4	12,690.8	12,186.4	9,698.4	9,581.1	9,414.2
2	Баян-Өлгий	6,222.2	5,927.8	8,360.3	8,360.3	6,414.3	6,361.4	10,073.8	9,912.0	11,949.5	11,467.1	9,395.6	9,310.6	10,828.9
3	Баянхонгор	6,425.8	5,936.9	8,091.9	8,091.9	10,140.5	10,113.3	15,405.3	15,192.4	21,577.0	20,790.0	18,124.8	17,926.8	21,974.4
4	Булган	3,292.5	2,889.4	4,244.2	4,244.2	6,066.6	6,056.4	9,369.0	9,051.6	14,228.4	13,675.4	11,079.8	10,967.7	10,666.9
5	Говь-Алтай	7,569.7	7,379.5	10,079.4	10,079.4	10,142.7	9,875.5	15,122.9	14,863.8	17,357.4	16,596.2	18,303.7	18,128.8	19,801.8
6	Дорноговь	15,224.8	15,220.4	19,336.3	19,336.3	17,382.5	17,322.3	26,870.3	25,571.4	42,708.1	40,852.2	33,362.2	32,734.6	34,920.2
7	Дорнод	6,927.6	6,591.9	9,205.8	9,205.8	14,952.2	14,946.5	21,499.5	20,380.7	25,422.0	24,115.3	22,933.7	22,333.7	27,807.2
8	Дундговь	5,176.6	4,972.6	6,694.7	6,694.7	7,875.3	7,875.3	11,875.4	11,563.0	15,880.4	15,334.9	13,039.8	12,774.7	13,480.7
9	Завхан	4,508.3	4,276.8	5,987.6	5,987.6	7,184.6	7,184.6	15,043.1	14,836.0	14,700.7	14,095.3	12,419.4	12,310.4	11,862.2
10	Өвөрхангай	5,753.9	5,307.0	7,711.2	7,711.2	7,785.1	7,723.0	12,166.4	11,925.3	14,480.8	13,880.1	12,182.2	11,992.2	12,661.4
11	Өмнөговь	14,188.5	13,941.3	17,014.6	17,014.6	18,861.4	18,824.2	28,685.2	28,262.2	47,716.0	46,025.8	43,799.7	43,056.0	42,558.7
12	Сүхбаатар	12,621.5	12,579.7	16,679.2	16,679.2	12,058.7	11,832.5	17,153.8	16,990.7	18,215.7	17,515.4	19,709.5	19,533.1	20,827.5
13	Сэлэнгэ	7,739.5	7,739.5	10,341.5	10,341.5	12,119.5	12,119.5	20,328.8	20,170.6	27,768.4	26,784.6	23,056.1	22,954.9	24,972.6
14	Төв	7,125.6	6,744.1	9,333.7	9,333.7	12,524.3	12,408.3	20,671.3	20,398.0	28,366.8	27,395.6	24,987.5	24,820.0	22,891.4
15	Увс	5,570.7	5,308.4	7,535.4	7,535.4	7,211.0	7,103.9	11,324.0	11,080.4	13,069.0	12,546.3	10,770.9	10,680.6	12,455.4
16	Ховд	9,703.2	9,491.0	13,179.9	13,179.9	10,794.5	10,794.5	19,255.4	19,051.1	29,385.2	28,327.4	18,010.8	17,917.9	18,950.1
17	Хөвсгөл	7,142.8	6,730.0	9,641.3	9,641.3	8,823.0	8,812.6	14,403.3	14,200.9	16,739.1	16,065.8	14,457.7	14,335.9	14,593.2
18	Хэнтий	7,273.8	7,240.5	9,758.7	9,758.7	7,856.3	7,856.3	12,451.2	12,166.2	18,587.1	17,914.6	16,234.2	16,077.6	19,238.7
19	Дархан-Уул	6,423.7	6,380.9	8,676.2	8,676.2	8,467.2	8,466.5	13,473.2	13,362.7	20,763.4	20,023.7	13,203.6	13,134.3	12,586.4
20	Улаанбаатар	23,201.5	21,653.0	33,036.2	33,036.2	26,048.1	26,017.2	41,325.1	40,715.7	50,167.0	48,042.6	39,536.7	39,160.6	42,639.9
21	Орхон	4,295.9	4,006.5	5,353.7	5,353.7	9,915.5	9,836.3	16,970.4	16,782.3	34,710.3	33,480.2	26,251.7	26,174.1	30,640.9
22	Говьсүмбэр	1,140.0	1,016.0	1,558.1	1,558.1	3,205.1	3,205.1	5,731.5	5,643.2	7,000.3	6,740.7	5,829.7	5,766.6	5,118.2
<b>Нийт дүн</b>		<b>172,306.6</b>	<b>165,671.8</b>	<b>228,260.8</b>	<b>228,260.8</b>	<b>232,644.3</b>	<b>231,551.2</b>	<b>369,939.3</b>	<b>362,691.5</b>	<b>503,483.6</b>	<b>483,855.4</b>	<b>416,377.6</b>	<b>411,672.3</b>	<b>440,891.0</b>

/сая төг/